



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/190

Булган сум

“Бидний гоёл 2025” тэмцээнд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөр”-ийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багш, сурагчдын загвар зохион бүтээх, өөрийгөө нээн хөгжүүлэх, урлан бүтээх, чадварыг дээшлүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсад Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүссэний 100 жилийн ойн нэрэмжит “Бидний гоёл-2025” тэмцээнийг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Боловсролын газар (Ц.Цолмонбаатар)-т даалгасугай.

2.Орхон, Дархан-Уул, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийг оролцуулан зохион байгуулагдах “Бидний гоёл-2025” тэмцээнд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

3.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР